

ШИВЭЭГОВЬ СУМЫН 2024 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

2024.09.20

Шивээговь сум

НЭГ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Сумын Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулж, сумын Засаг даргаас 5 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Сумын Засаг даргын Зөвлөлийн хурлыг 09 дүгээр сард зохион байгуулаагүй байна.

“Шивээговь сум мэдээ” цахим хаягаар нийт-47 мэдээллийг нийтлэн, бусад байгууллагын 25 мэдээллийг шэйрлэн, шинээр-22 мэдээ мэдээллийг иргэдэд хүргэн ажилласан. 2024 оны 09 дүгээр сарын 20-ны байдлаар сумын цахим хуудасны нийт дагагчийн тоон үзүүлэлт-4470 болсон байна. Сумын хэмжээнд болж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг тогтмол оруулан, бусад зар мэдээллийн 8 группэд дамжуулан иргэдэд хүргэн ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлт болон халамжийн үйлчилгээг нийт 76 иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 26 иргэнд, халамжийн 11 төрлийн үйлчилгээг 50 иргэнд тус тус хүргэсэн байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн 4 төрлийн төсөл арга хэмжээний төсөл болон Нийгмийн халамжийн хэлтсийн Олон нийтийн оролцооны бүлгийн төсөл хүлээн авч байна. 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 5 иргэний 2 төслийг хүлээн авсан байна. Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж 8 иргэний өргөдлийг хүлээн авч, 2 иргэний бүтэн өнчин хүүхдийн асаргааны тэтгэмжийн сунгалт, 1 иргэнийг байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргаанд, 2 ахмад настны асаргааны сунгалтыг хэлэлцэж дэмжин, тэтгэмжид хамруулсан.

ХОЁР. ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Намрын нэгдсэн эргүүл шалгалтын ажлын хүрээнд 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 09 дүгээр сарын сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд намрын нэгдсэн эргүүл шалгалтыг сумын хөдөөгийн багийн хүрээнд хийж, нийт 60 өрхөөр тойрон өвөлжилтийн бэлтгэл ажлын талаарх албан бичиг, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаарх гарын авлага, малчдын өдөрлөгийн зар мэдээлэл, хадсан өвс, хадлан зэрэгтэй танилцан, шаардлагатай мэдээллийг хүргэн ажиллаад байна.

Сумын хэмжээнд Олон улсын “Ахмадын баяр”-ыг угтан Засаг даргын Тамгын газар, албан байгууллагууд хамтран Ахмадын баярын арга хэмжээг 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд аймаг орон нутагтаа олон жил үр бүтээлтэй ажилласан ахмад настнуудынхаа хөдөлмөр бүтээлийг үнэлж, “Говьсүмбэрийн төлөө” медаль, сумын Засаг даргын жуух бичиг, сумын “Ахмадын хороо”-ны ажлыг өндрөөр үнэлж ИТХ-ын талархлаар тус тус шагнаж, байгууллагуудын нэгдсэн хүндэтгэлийн тоглолтын арга хэмжээг зохион байгуулан тэмдэглэн өнгөрүүлээ.

Сумын Сонгуулийн хороо, Хэсгийн хороодууд холбогдох хууль дүрэм журмыг мөрдлөг болгон, хуульд заасан хугацааны дагуу ажил чиг үүргээ гүйцэтгэн ажилласан байна.

ГУРАВ. ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВ САНХҮҮГИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

2024 оны 09 дүгээр сарын байдлаар сумын төсвийн орлого төлөвлөгөөгөөр 16 төрлийн татварын орлого гүйцэтгэлээр 1,477,126,523 төгрөг бүрдэж, биелэлтээр 99.55%-тай бүрдсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн 6н байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 2024 оны 09 дүгээр сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 100 хувьтай, байршуулвал зохих 98 мэдээллийг ил тод мэдээллэсэн байна.

ДӨРӨВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/116 дугаар захирамжийн дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүн төрөөс баримталж байгаа хүнсний эрүүл ахуйн чиглэлээр сумын хэмжээнд хяналт шалгалтын ажил зохион байгуулан ажиллаж, Хяналт шалгалтад Хүнсний дэлгүүр 10 цайны газар 2 Төсвийн 2 байгууллага хамрагдаж 64 нэр төрлийн 661 ширхэг хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч дараагийн шатны байгууллагад шилжүүлж ажилласан бөгөөд 2024 оны 09-р сарын 10-нд буюу өнөөдөр хураагдсан хугацаа нь дууссан хүнсний бүтээгдэхүүнийг аймгийн Хүнс Хөдөө Аж ахуйн Улсын байцаагч ирж устгалын ажлыг хийлээ.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сумын “Дэвжих таван эрдэнэ хоршоо”, “Танхил хундар үйлс хоршоо”-д Баянтал сумын нутаг дэвсгэр болох Малхын тал гэх газраас хадлан бэлтгэхээр 2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн ажиллаж байна. Хоршоо тус бүр 300 га талбайд хадлан бэлтгэж, 09 дүгээр сарын 20-ны байдлаар нийт 5900 боодол хадлан өвсийг бэлтгээд байна.

Сумын тариалан эрхлэгч нар 09 дүгээр сарын 20-ны байдлаар 3.133 га талбайгаас нийт 24.827 тн хүнсний ногооны ургацыг хураагаад байна.

ТАВ. ДЭД БҮТЭЦ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

1. **-Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар** батлагдсан 3 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан. Үүнд:

- ✓ Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажил /09.08/
- ✓ Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах ажил /09.18/
- ✓ Ёслол хүндэтгэлийн өргөө гэр авах ажлуудын тендерийг /09.08/ тус тус зарлаад байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар суманд хийгдэж буй “150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил” нь 2022-2024 он хүртэл хийгдсэн бөгөөд 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Улсын комисс ажиллаж, комиссын гишүүдийн үүрэг даалгаварын 100%-н биелэлтээр байнгын ашиглалтад авахаар шийдвэрлээд байна.

Шивээговь сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй Хуучин хог хаягдлыг булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажил, Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг дэмжих /байр засварлах/ зэрэг ажлууд үргэлжлэн хийгдэж, 90-98%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр ажлыг хүлээн авахаар ажиллаж байна.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасныг үндэслэн худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгон зарласан байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан-3

ЗУРГАА. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Эрүүл мэндийн чиглэлээр: Сумын Эрүүл мэндийн төвд улирлын томуу, томуу төст өвчний дархлаажуулалтын вакциныг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс хийж эхэлсэн бөгөөд 2024 оны 09 дүгээр сарын 20-ны байдлаар 77 хүн хамрагдаад байна. Мөн хичээл сургуулийн улирал эхэлсэнтэй холбоотойгоор цэцэрлэгийн 2-5 насны 229 хүүхэд, ЕБС-ийн дотуур байрны 8 хүүхдүүдийг цагаан хорхойн шинжилгээ болон анхан шатны үзлэг, амны хөндийн үзлэгт хамруулсан.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

“Хог хаягдлын менежмент” арга хэмжээний хүрээнд төсвийн байгууллагууд, ААН-үүд 14 хоног тутам өөрийн эзэмшлийн 50м хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэж байна..

Золбин нохой, муур устгалын ажлыг 2024 оны 09 дугаар сарын 10-ны өдрийн өглөөний 06 цагаас 15 цаг хүртэл зохион байгуулж ажилласан. Устгалын ажлыг зохион байгуулахаас өмнө зар мэдээг сумын цахим мэдээллийн сувгаар иргэдэд зар мэдээг хүргэж ажилласан. Золбин нохой, муур устгалаар сумын 1-р багийн 2,3,5,6,7,8,9,10,12,13,14,15-р байр, 2-р багийн зүүн гэр байр, урд гэр байр, 22-р зөрлөг, Страто ХХК, 21-р зөрлөг, сумын төвийн төв хогийн цэг гэсэн маршрутаар явж ажилласан. Устгалаар 37 нохой, 15 муур нийт 52 ширхэг золбин нохой, муурыг устгасан байна.

2024 оны 9 сарын 4-ний өдөр сумын Засаг даргын Тамгын газар нь ШОХК-тай хамтран бороо орсны улмаас ус тогтдог хонхор газар болон сумын төвийн зам, цэцэрлэгийн зүүн тал, 8 дугаар байрны хажуу талын эвдрэл гэмтэлтэй газарт шороо асгаж түрж тэгшлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Шивээговь сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Хуучин хог хаягдал булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажил”-ын явц 90 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр гэрээний хугацаа дуусч, ажлыг хүлээн авна.

МЭДЭЭГ БЭЛТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН

МЭРГЭЖИЛТЭН

М.ГАНТУЯА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ